



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/581

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “Аймгийн 2021 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 4/03 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 72 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүн амын хүнсний хангамж болон малын өвс, тэжээлийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг тогтвортой хангах нөхцөлийг бүрдүүлэх, газар тариалангийн салбарын техникийн хангамжийг сайжруулан тариалан эрхлэх ажиллагааг механикжуулж, бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйг дэмжих сангаас “Шинэ Ховд-Баруун бүсийн хөгжлийн корпораци” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт зээлээр олгож байгаа 2 тракторыг ачиж буулгах, тээвэрлэх зардалд 10 800 000 төгрөг /арван сая найман зуун мянга/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах нийт 10 800 000 мянган төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны батлагдсан төсвийн 4.18-9-д заасан хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zah A/581 Kh
02 2339

Аймгийн Засаг даргын 2021 оны
10 дугаар сарын 18-ны өдрийн
А/581 дүгээр захирамжийн хавсралт



**ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ САНГААС ЗЭЭЛЭЭР ОЛГОЖ БАЙГАА
ТРАКТОРЫГ АЧИЖ БУУЛГАХ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Хүлээн авах байгууллагын нэр	Техникийн марк	Тоо	Зардал	
				Нэр	Нийт дүн /төгрөг/
1..	Шинэ Ховд-Баруун бүсийн хөгжлийн корпораци ОНӨААТҮГ	МТЗ-82.1 трактор	2	Улаанбаатараас ачиж Ховдод буулгах краны зардал	10 800 000
		Хадуур ХЦН-210	1	400 000 төг * 2 удаа = 800 000 төгрөг	
		Тармуур ГДР-630	1	Улаанбаатараас Ховд тээвэрлэх зардал	
		Пресс ППТ-160	1	5 000 000 төгрөг *2 ширхэг = 10 000 000 төгрөг	
	Нийт дүн			5	

-оОо-